



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/759

Булган сум

**Багш нарын практик сургалтыг  
зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.4.1, аймгийн Засаг даргын 2023 оны А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны газар болон Монгол улсын Багшийн их сургуультай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд зохион байгуулагдах Дүрслэх урлаг, дизайн технологийн багш нарын практик сургалтыг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар тус тус баталж удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Ганболд)-т даалгасугай.

2.Дүрслэх урлаг, дизайн технологийн багш нарын практик сургалтыг зохион байгуулахад шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг “Шинэ багш” хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
11 дүгээр сарын 08-ны өдрийн А/759 дугаар  
захирамжийн хавсралт

**ДҮРСЛЭХ УРЛАГ, ДИЗАЙН ТЕХНОЛОГИЙН БАГШ НАРЫН  
ПРАКТИК СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Сургагч багш нарын хөлс	4	500,000	2,000,000
<b>Нийт</b>				<b>2,000,000</b>